



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/64

Хэрлэн сум

Спортын наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай журам"-ын 2 дугаар заалт, 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоол, 2021 оны "Спортын наадам хойшлуулах тухай" 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын бүх ард түмний спортын XY наадам, Монголын Үндэсний спортын YII наадамд оролцох бэлтгэл ажлыг хангах зорилгоор орон нутагт I, II шатны шалгаруулалтыг 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Наадам зохион байгуулах зардлыг 2022 оны батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэхийг Биеийн тамир, спортын газрын дарга Г.Нэргүйбаатар, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа нарт даалгасугай.

3. Монголын бүх ард түмний спортын зуны XY наадам, Монголын Үндэсний спортын YII наадмыг Зохион байгуулах салбар хороог доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны

дарга:

Л.Батсайхан

Засаг даргын орлогч

Салбар хорооны

дэд дарга:

Г.Нэргүйбаатар

Биеийн тамир, спортын газрын дарга

Гишүүд:

Ч.Баярцолмон

Дугуйн холбооны Нарийн бичгийн дарга

Г.Лхагвахатан

Хөнгөн атлетикийн холбооны тэргүүн

Э.Мөнх-Эрдэнэ

Сагсан бөмбөгийн холбооны тэргүүн

Д.Батхүү

Цагдаагийн газрын дарга

Н.Зоригтбаатар

Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

231010207

2.

Л.Бат-Октябрь	Хүндийн өргөлтийн холбооны Нарийн бичгийн дарга	
Б.Одхүү	Аймгийн Жүдо бөхийн холбооны тэргүүн	
З.Энхболд	Аймгийн Волейболын холбооны Нарийн бичгийн дарга	
П.Оростогоо	Аймгийн Самбо бөхийн холбооны тэргүүн	
Г.Ангараг	Аймгийн Шагайн холбооны Нарийн бичгийн дарга	
Н.Тэгшжаргал	“Сэцэн хааны хүлэг” Морин спортын холбооны тэргүүн	
Л.Цогтгэрэл	Үндэсний сурын холбооны Нарийн бичгийн дарга	
Ш.Шинэбаяр	Урианхай сурын холбооны Нарийн бичгийн дарга	
Т.Баяржаргал	Өсвөрийн шигшээ багийн буудлагын спортын дасгалжуулагч	
Нарийн бичгийн дарга:	Ч.Бат-Эрдэнэ	Биеийн тамир, спортын газрын Албаны дарга
	Г.Солонго	Биеийн тамир, спортын газрын Албаны дарга

4. Наадмыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж хяналт тавьж  
ажиллахыг салбар хорооны дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

